



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.09 № 01/830  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-  
ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
ХИШИГБАЯРЫН БАДРАХГЭРЭЛ  
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Хишигбаярын Бадрахгэрэлийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хишигбаярын Бадрахгэрэлийн Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Хишигбаярын Бадрахгэрэлийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (1 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Хишигбаярын Бадрахгэрэлд

Хувийг: Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Сонгуулийн хороонд

Хавсралт . . . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР




ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬД  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ХИШИГБАЯР ОВОГТОЙ БАДРАХГЭРЭЛ  
МИНИЙ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

НЭГ:Ерөнхий агуулга

Сум орныхоо хөгжил дэвшлийн төлөө санаа бодлоо илэрхийлж ИТХ-ын шийдвэр гаргуулахын төлөө, иргэдээ төлөөлөн идэвх санаачилгатай ажиллана

ХОЁР: Хөтөлбөрийн үндсэн заалт

- ❖ Малын чанарт анхаарч, сүргийн бүтцийг сайжруулах, хээлтэгч хээлтүүлэгчийн зохистой харьцааг бий болгох бодлого барьж ажиллана.
- ❖ Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, зах зээлд нийлүүлэх борлуулалтын нэгдсэн сүлжээг бий болгох бодлого барьж ажиллана.
- ❖ Цөөн малтай малчин өрхийг “ Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт”- т болон “Чинээлэг малчин” хөтөлбөрт хамруулах ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- ❖ Өрхийн түвшинд хүнсний ногоо, хүлэмж, жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэх нэр төрлийг олшруулах бодлогыг дэмжиж ажиллана.
- ❖ Зөгийн аж ахуйг дэмжин, бүлийн тоог нэмэгдүүлэх, шинэ зоорь барих, зөгийчдийн холбоодтой холбох ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- ❖ Малчдын бүлэг, хуримтлалын бүлгийн ололт туршлагыг улам дэлгэрүүлж, иргэдээс гарсан үүсэл санаачилгыг дэмжиж ажиллана.
- ❖ Алсын бэлчээр ашиглалтыг /Алагцар, Хээгцэр гэх мэт/ нэмэгдүүлэх бодлого баримталж отор нүүдэл хийсэн айл өрхийг бодлогоор дэмжинэ.
- ❖ Малчин өрхийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, орон сууц, хашаа хадлагийн талбайг хамгаалахад мод, модон материал олгогдох нөхцөлийг сайжруулах талаар эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэхийн төлөө ажиллана.
- ❖ Малчдад туслан дэмжих зорилгоор фондын өвсийг нэмэгдүүлэх чиглэлээр бодлого гаргаж, иргэд, аж ахуйн нэгжүүдтэй хамтарч ажиллана.



МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН Б.БАДРАХГЭРЭЛ

*Б.Бадрахгэрэл*

000000001